



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

Дэлжин оны 05 сарын 10 өдөр

Дугаар 1/89

Мандалговь

“Сайнцагаан сумын 6,7,8 байрны гадна фасад,^т
тохижилт, дээврийн зураг төсөв боловсруулах”
зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээн авах комисс томилох тухай

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 11.4, 16.3 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Сайнцагаан сумын 6,7,8 байрны гадна фасад, тохижилт, дээврийн зураг төсөв боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Э.Чагнаадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: О.Мөнхзул (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Гишүүд: Э.Энхмэнд (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн даргын түр орлон гүйцэтгэгч)

Э.Дүүрэнжаргал(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Булган (“Скеч” ХХК-ний захирал)

2. Сайнцагаан сумын 6,7,8 байрны гадна фасад, тохижилт, дээврийн зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Э.Чагнаадорж)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ /Доржбат/ Л.ДОРЖБАТ

486210392